



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жэнжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2024. 11. 21 № ХӨТ/2314
танай _____-ны № _____-т

**Ерөнхий сайдын мэдээлэл
хүргүүлэх тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112.2-т заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанд хийх "Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын хэлэлцээ"-ний явцын талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 04 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХӨРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



Н.УЧРАЛ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Л.ОЮУН-ЭРДЭНИЙН
УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД
ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

**Гашуун сухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам барих
хэлэлцээний явцын талаар**

1.Эрх зүйн орчны талаар

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр заасны нэгдүгээрт "Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина" гэж тусгасан.

Мөн Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод "Стратегийн орд газруудыг хилийн боомттой холбосон төмөр замуудыг барьж, байгуулна." гэж, "Эдийн засгийн тэргүүлэх салбаруудыг хөгжүүлж, экспортын баримжаатай эдийн засгийг бий болгоно." гэж, Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн Боомтын сэргэлтийн хүрээнд "Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ" гэж, "Үндэсний төмөр замын сүлжээг өргөтгөж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлж, баруун болон зүүн босоо тэнхлэгийн төмөр замын төслүүдийг эрчимжүүлнэ." гэж, 2010 оны 32 дугаар тогтоолоор баталсан "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын 1.2.1.2-т "ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн сүлжээг ашиглан гуравдагч зах зээлд хүрэх худалдаа тээврийг хөнгөвчилсөн шинэ замнал /маршрут/-ыг бий болгон далайн боомтуудад гарцтай болох" гэж тус тус заасан.

Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам болон Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалттай холбоотойгоор 2008 оноос 2024 оны хооронд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2 зөвлөмж, Монгол Улсын Их Хурлын 5 тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 45 тогтоол, тэмдэглэл зэрэг эрх зүйн баримт бичгүүдийг баталсан.

2014 оны 8 дугаар сард байгуулсан "Монгол Улс, БНХАУ-ын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал"-д "...Талууд Эрдэс баялгийг нээн олборлох, дэд бүтцийн бүтээн байгуулалт, санхүүгийн хамтын ажиллагааг уялдуулан цогц байдлаар хөгжүүлэх зарчмын дагуу бүх талын харилцан ашигтай хамтран ажиллах байдлаар тохиролцсон.

Төмөр зам барих тусгай зөвшөөрлийг 2008 оноос хойш 5 удаа олгож, 4 удаа цуцалсан, төмөр замын царигийн хэмжээг 4 удаа өөрчилсөн, хилийн цэг тохирох талаар 5 удаа яриа хэлэлцээг хийж, 2021 онд хоёр улсын хилийн 703-р баганаар тохиролцсон байна.

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 252 дугаар тогтоолоор Ухаахудагийн ордоос Гашуунсухайт боомт хүртэлх төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг "Энержи Ресурс" ХХК-д олгосон бөгөөд тус компани төмөр замын ТЭЗҮ-ийг нарийн царигтайгаар боловсруулж, БНХАУ-ийн Шенхуа компани /одоогийн Чайна Энержи групп компани/-тай хамтарч ажиллах талаар компанийн түвшинд яриа хэлэлцээ хийж эхэлсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ыг баталж, "бүтээгдэхүүн нь экспортод шууд тээвэрлэгдэх хилийн боомтын төмөр замын шугамын царигийн өргөнийг Монгол Улсын Засгийн газар Монгол Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэх"-ээр зохицуулсан.

БНХАУ-ын дарга Ши Жиньпин 2014 оны 08 дугаар сард Монгол Улсад Төрийн айлчлал хийх үеэр "хэрэв Монгол Улс өмнөд чиглэлийн төмөр замыг нарийн царигаар барьж байгуулсан тохиолдолд Хятадын тал санхүүгийн дэмжлэг үзүүлэхэд бэлэн" болохоо илэрхийлсэн.

Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолоор Тавантолгой уурхайд хөрөнгө оруулах, олборлолтыг нэмэгдүүлэх, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр зам, уул уурхайн хөрөнгө оруулалтыг цогцоор нь гүйцэтгэхээр, Монгол Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолоор Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг нарийн царигаар барихаар шийдвэрлэсэн байна.

Гэвч Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 268 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Мега төсөл хариуцсан сайд М.Энхсайханы ахалсан яриа хэлэлцээний явцад тохирсон гэрээний төслийг 2015 оны 5 дугаар сард Улсын Их Хурлаар хэлэлцүүлж дэмжигдээгүй бөгөөд Тавантолгойн уурхай болон төмөр замтай холбоотой Хятадын талтай хийгдэж байсан яриа, хэлэлцээ зогсонги байдалд оржээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2020 оны 04 дүгээр дүгнэлт гаргаснаар Монгол Улсын Их Хурлын 2014 оны 64 дүгээр тогтоолыг хүчингүй болгож, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг өргөн царигтай барьж байгуулахаар барилгын ажлыг эхлүүлэн 2023 онд бүтээн байгуулалтын ажлыг дуусгаж ашиглалтад оруулсан болно.

Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам, БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо хооронд 2022 оны 08 дугаар сарын 08-ны өдөр харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээрийг байгуулсан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 310 дугаар тогтоолын хүрээнд байгуулагдсан Ажлын хэсгийн яриа хэлэлцээний үр дүнд Төмөр замын гүүрэн байгууламжийг хамтран барих Засгийн газар хоорондын хэлэлцээрийг 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр байгуулж, эрх зүйн хувьд хил холболтын төмөр замыг барьж байгуулах асуудал шийдэгдээд байна.

II. Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын талаар

Гашуунсухайт-Ганцмод төмөр замын төслийн төсөвт өртөг нарийвчилсан зураг төслийн дагуу 979 тэрбум төгрөг байхаар урьдчилсан тооцоолол гарч байгаа бөгөөд санхүүжилтийн асуудлыг Монгол Улсын Их Хурлын 2023 оны 68 дугаар тогтоолоор "Эрдэнэс Тавантолгой" ХК хариуцахаар шийдвэрлэгдсэн. Одоогийн байдлаар төмөр замын төслийн ТЭЗҮ, зураг төсөл хийгдэж дууссан, барилгын ажлын гэрээний төслийг компанийн хэмжээнд тохироод байгаа болно.

Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам нь 1-р зэрэглэлийн, 1520 мм өргөн цариг, 1435 мм нарийн царигийн хос замтай, гол замын урт 19.5 км, өргөн царигаар жилд 30 сая.тн, нарийн царигаар жилд 10 сая.тн ачаа тээвэрлэх хүчин чадалтай болно. БНХАУ-ын "Төмөр замын зураг төслийн корпорац /CRDC/" компани ТЭЗҮ, нарийвчилсан зураг төслийг гүйцэтгэн бүрэн дууссан болно.

БНХАУ-ын талаас эхний ээлжид Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замыг барьж, ашиглалтад оруулсны дараа нөхцөл нь бүрдсэн бусад боомтуудыг төмөр замаар холбох байр суурийг байнга илэрхийлсээр ирсэн. Тухайлбал, 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр БНХАУ-ын Гадаад хэргийн сайд Ван И: "Хөгжил, шинэчлэлийн хорооны одоогийн байр суурь бол Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замыг эхний ээлжид дуусгахад анхаарч байна" гэдгээ илэрхийлсэн.

Монгол Улсын Ерөнхий Сайдын 4 удаагийн захирамжаар "1955 оны "Монгол, Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр" болон "Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотойгоор авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг"-ийг байгуулсан бөгөөд Ажлын хэсэг 2022 оноос хойш БНХАУ-ын талтай давхардсан тоогоор 60 орчим удаа уулзалт, хэлэлцээ хийсэн бөгөөд хэлэлцээ үргэлжилж байна.

БНХАУ-ын Чайна энерги групп компаниас 2024 оны 10 дугаар сарын 28-ны өдөр "хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалт, нүүрсний худалдаа, нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааг цогцоор шийдвэрлэх тухай хүсэлт"-ийг ирүүлсэн бөгөөд тус хүсэлтэд Хятадын тал нь боомтын төмөр зам барьсан хөрөнгө оруулалт 7.17 тэрбум юань, 10 жилийн хугацааны алдагдал 2.7 тэрбум, цаашид шаардлагатай нэмэлт хөрөнгө оруулалт 4.1 тэрбум юань зэрэг нийтдээ 13.97 орчим тэрбум юанийн алдагдал хүлээгээд байгаа талаар албан бичигт тусгасан байна.

III. БНХАУ-ын талаас тавьж буй саналын талаар

Хятадын "Чайна Энержи групп" компаниас Монголын тал өндөр дээд бүхий л түвшинд өгсөн үүрэг амлалтынхаа дагуу нүүрсний урт хугацаат гэрээ байгуулах, Тавантолгой ордын хүчин чадлыг нэмэгдүүлэх, Гашуунсухайт-Ганцмодын төмөр замын хил холболтын бүтээн байгуулалтыг "гурвыг цогцоор" шийдвэрлэх хамтын ажиллагааны саналыг ирүүлээд байгаа бөгөөд эдгээр асуудлыг шийдсэн тохиолдолд өнгөрсөн хугацааны алдагдал, хохирол, алдагдсан боломжийг нэхэмжлэхгүй, ордын эзэмшилд оролцохгүй гэдгээ илэрхийлж, хамтран ажиллах дараах саналыг тавьсан. Үүнд:

1. Нүүрсний урт хугацаат худалдааны гэрээ байгуулж, 2025-2029 онд 27 сая тонн, 2030 оноос нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлсний үндсэн дээр жил бүр 20 сая тонноос дээш хэмжээний нүүрсийг урт хугацаанд худалдах, худалдан авах. Худалдааны үнийг тогтоохдоо хоёр талын яриа хэлэлцээний түүхэн улс төрийн нөхцөл байдал, алдагдсан боломжийн өртөг, алдагдал, хөрөнгө оруулалтын хэмжээг тооцож, зах зээл дээр өрсөлдөхүйц үнэ тогтоох оновчтой механизмыг ашиглах;
2. "Чайна энержи групп"-ээс "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн зарласан олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтад оролцох боломжтойг илэрхийлсэн бөгөөд "гурвыг цогцоор" зарчмын хүрээнд хайгуул-олборлолтын гэрээг мөн адил урт хугацаагаар байгуулах;
3. Гашуунсухайт-Ганцмодны хил дамнасан төмөр замыг хамтран байгуулах бөгөөд төмөр зам ашиглалтад орсны дараа бусад нүүрсний худалдаа эрхлэгчдийн ачааг зах зээлийн зарчмаар өөрсдийн эзэмшлийн төмөр замаар тээвэрлэх.

"Чайна энержи групп"-ээс ирүүлсэн дээрх санал нь хоёр талын хамтын ажиллагааны түүх, төслийн хэрэгжилтийн олон улсын практикт үндэслэн, шударга, эрх тэгш, харилцан итгэлцсэн, харилцан ашигтай байх хамтын ажиллагааны зарчмын дагуу гэж тайлбарлаж байгаа бөгөөд энэхүү хамтын ажиллагааг хэрэгжүүлснээр Монгол, Хятадын хооронд харилцан тохиролцсон олон томоохон төсөл, арга хэмжээ хэрэгжих боломжтой болно гэж үзэж байна.

Гашуунсухайт-Ганцмодны хил дамнасан төмөр замын төсөл хэрэгжсэнээр бусад хилийн боомтуудын хил холболтын төмөр замын төслүүд хэрэгжиж манай улсын нийт нүүрсний экспорт 165 сая тоннд хүрч, нүүрсний салбарын экспортын орлого жилд дунджаар 2.61 тэрбум ам.доллар байгааг 2.8 дахин нэмэгдүүлж, 7.4 тэрбум ам.долларт хүрэх, эдийн засгийн өсөлт 0.8 нэгж хувиар нэмэгдэх, ядуурлын түвшин буурч, нэг хүнд ногдох ДНБ-ийг 10000\$-т хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6%-аас дээш түвшинд хадгалах, инфляцыг 5%-д барих боломж бүрдэнэ гэж тооцоолж байна.